



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/К

Дэлгэрхаан сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
өвлүүлэн эзэмшүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Газрын тухай" хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авах хүсэлт гаргасан иргэн Б.Энхчимэг (РД: СЛ87051803)-д түүний аав Н.Бат-Эрдэнийн эзэмшиж байсан 3 дугаар багийн нутаг Аварга тосонд байрлах 700 кв.м газар эзэмших эрхийн гэрчилгээг 45 жилийн хугацаатай өвлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулж, газар эзэмшилтэнд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ч.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг (Б.Энхчимэг)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 63 дугаартай захирамжийн (Н.Бат-Эрдэнэ)-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

